

## БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ

### /Өрийн хэрэгсэл/

20.. оны ... дугаар сарын ...-ны өдөр

№...

Улаанбаатар хот

Нэг талаас: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид Бирж гэх/, түүнийг төлөөлж Хяналт, зохицуулалтын газрын захирал.....,

Нөгөө талаас: “.....” ХК /цаашид Үнэт цаас гаргагч гэх/, түүнийг төлөөлж ..... нар /хамтад нь Талууд гэх/,

### Нэг. Гэрээний нөхцөл

Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хорооны болон Биржийн холбогдох дүрэм, журам, зааврын хүрээнд Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгслийг Биржид бүртгэх, арилжих, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор дараах нөхцөлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав. Үүнд:

- 1.1. Бирж нь Үнэт цаас гаргагчийн гаргасан ..... /...../ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ..... /...../ ширхэг компанийн өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэж, өөрчлөлтийг тухай бүр хөтлөн, өрийн хэрэгслийн арилжааг зохион байгуулах ажиллагааг зохих дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 1.2. Үнэт цаас гаргагч нь арилжигдсан өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлж барагдуулна.
- 1.3. Үнэт цаас гаргагч нь Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын Хавсралт 1-ийн Хүснэгт 2-т заасны дагуу тооцон, үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлсийг анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан тухай бүр ажлын 3 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
- 1.4. Үнэт цаас гаргагч нь Биржийн “Арилжааны журам”-ын Хавсралт 1-д заасны дагуу өрийн хэрэгслийг анхдагч зах зээл дээр арилжаалсан үнийн дүнгээс 0.1575 хувиар тооцон, арилжааны шимтгэлийг Биржид төлнө.
- 1.5. Үнэт цаас гаргагч нь компанийн өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд санал болгох тухай мэдэгдлийг түүнийг эхлүүлэхээс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө Биржид албан бичгээр мэдэгдэх бөгөөд уг мэдэгдэлд дараах мэдээллийг хавсаргана. Үүнд:
  - 1.5.1. Өрийн хэрэгслийн нөхцөл;
  - 1.5.2. Анхдагч зах зээлийн арилжааны захиалга авах нөхцөл: захиалга авч эхлэх огноо, үргэлжлэх хугацаа, санал болгох арга хэлбэр г.м;

- 1.5.3. Бондын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа тохиолдолд: Сүүлийн улирлын санхүүгийн тайлан, үнэт цаасны танилцуулгад заасан үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээлэл, өрийн хэрэгсэл гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан;
  - 1.5.4. Үнэт цаасны танилцуулгад орох нэмэлт өөрчлөлтүүд /шаардлагатай тохиолдолд/: үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, зах зээлийн орчин, санхүүгийн байдал зэрэгт орсон томоохон өөрчлөлтүүд буюу хөрөнгө оруулагчдын шийдвэрт материаллаг нөлөө үзүүлэхүйц мэдээллийг тусгасан Үнэт цаасны танилцуулгын нэмэлт хавсралт.
- 1.6. Үнэт цаас гаргагч нь дараах мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт тухайн үйл явдал болсон даруйд буюу ажлын 1-3 өдрийн дотор Биржид ирүүлнэ. Үүнд:
    - 1.6.1. Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлт хийгдсэн тухай;
    - 1.6.2. Өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болох эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээг зохих хууль, дүрэм, журмын дагуу холбогдох этгээдэд бүртгүүлсэн, тусгаарлуулсан тухай;
    - 1.6.3. Төлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тухай, үнэт цаасны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан, авах арга хэмжээний тухай;
    - 1.6.4. Бүртгэлтэй үнэт цаастай холбоотой аливаа өөрчлөлт (өрийн хэрэгслийн нөхцөл, төлбөрийн хуваарь, нийтэд санал болгох хугацаа өөрчлөгдөх г.м)-ийн талаарх мэдээлэл;
    - 1.6.5. Үнэт цаас эзэмшигч, хөрөнгө оруулагчдын шийдвэр, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх бусад мэдээллүүд.
  - 1.7. Бирж нь Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгслийн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд зохих арга хэмжээг авхуулахаар холбогдох эрх бүхий байгууллагуудад хандах эрхтэй.
  - 1.8. Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хорооны болон Биржийн холбогдох дүрэм, журам, заавар, энэ гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүйгээс аливаа этгээдэд учирсан хохирлыг Үнэт цаас гаргагч, түүний холбогдох албан тушаалтан бүрэн хариуцна.

#### Хоёр. Хариуцлага

2.1. Үнэт цаас гаргагч нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Биржийн зүгээс хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд олгогдсон эрх хэмжээний дагуу арга хэмжээ авна.

2.2. Андеррайтер болон үнэт цаас гаргагчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан бусад этгээдэд учирсан хохирлыг Бирж хариуцахгүй.

#### Гурав. Маргаан шийдвэрлэх

3.1. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан аливаа маргаан, гомдлын шаардлага зэргийг талууд харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.

3.2. Хэрэв талууд гэрээтэй холбогдох маргааныг энэхүү гэрээний 3.1-т зааснаар шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### Дөрөв. Бусад зүйл

4.1. Гэрээг Монгол хэлээр 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг, нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

4.2. Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчлэх ба өрийн хэрэгслийн төлбөр бүрэн төлөгдөж, гэрээний үүргийн биелэлтийг хангаснаар дуусгавар болно.

4.3. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд тухайн нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

4.4. Гэрээг цуцлах тухай саналыг ажлын 5 өдрийн өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Биржийг төлөөлж:

Үнэт цаас гаргагчийг төлөөлж: “

Хяналт зохицуулалтын газрын захирал

.....” ХК-ийн

.....

.....